

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭНИЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ ЗАР

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/70, А/80 дугаар захирамжийг үндэслэн дор дурдсан байршилд газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдааг цахим хэлбэрээр /Интернетээр/ зохион байгуулахаар зарлаж байна.

1. Дуудлага худалдааны хэлбэр: Цахим хэлбэрээр /Интернетээр/ Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын дагуу дараах 2 байршилд газар эзэмших эрхийн гэрчилгээний нээлттэй дуудлага худалдаа явагдана.

I. Сүмбэр сумын 1 дүгээр багт, “Ник” ХХК-ийн албан байр, агуулахын баруун талд 10,3 га /103000м²/ газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар

II. Сүмбэр сумын 1 дүгээр багт, “108 Ойл” ХХК-ийн баруун хойд талд 20 га /200000м²/ газрыг үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус зарлаж байна.

2. Эзэмшүүлэх хугацаа: 15 жил /арван тав/

3. Анхны үнэ: 1-р байршил 61800000 /Жаран нэгэн сая найман зуун мянган/ төгрөг
2-р байршил 40000000 /Дөчин сая/ төгрөг

4. Дэнчин: 1-р байршил 6180000 /Зургаан сая нэг зуун наян мянган/ төгрөг
2-р байршил 4000000 /Дөрвөн сая/ төгрөгийг 100220029002 дансанд тушааж баримтыг хавсаргана.

5. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 39.1.6-д заасан хураамжийг 100220500941 дансанд тушааж баримтыг хавсаргасан байх.

6. Гэрээний зүйл: Сүмбэр сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд заасны дагуу ашиглахтай холбогдсон зураг төслийг газар эзэмших гэрээ байгуулснаас хойш 6 сарын дотор багтаан боловсруулж ирүүлнэ.

7. Цахим хуудас: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар нэвтэрч оролцоно.

8. Дуудлага худалдаанд оролцогчдыг бүртгэх хугацаа: Дуудлага худалдаанд оролцогчдыг 2018 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 08 цаг 30 минутаас эхлэн 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 08 цаг 30 минут хүртэл ажлын цагаар бүртгэж, баталгаажуулна.


9. Дуудлага худалдаа эхлэх: Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цагаас эхлэнэ.

10. Дуудлага худалдаа явагдах хугацаа: 2018 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 09:00 цагаас эхлэн 17:00 цаг хүртэл тасралтгүй үргэлжилнэ.


11. Дуудлага худалдаанд ялагчийг тодруулах журам: Дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн оролцогч ялагч болох бөгөөд ялагч нь дуудлага худалдаанд оролцох хүсэлтээ хугацаанд нь ирүүлж, дэнчин болон улсын тэмдэгтийн хураамжийг төлсөн, өөрийн мэдээллээ үнэн зөв гаргасан, дуудлага худалдааны дэг журмыг зөрчөөгүй байна.

12. Газрын байршил, хил хязгаарын зураг схем:

X=295863.717 Y=5141539.077
X=295964.340 Y=5141939.282
X=296219.564 Y=5141651.507
X=296739.739 Y=5142125.252
X=296846.922 Y=5142019.779
X=296279.890 Y=5141535.270
X=296235.500 Y=5141601.830



X=296256.303 Y=5137441.406
X=296573.205 Y=5137658.641
X=296599.830 Y=5137187.175
X=296338.671 Y=5137234.091



13. Техникийн нөхцлүүд: Цахилгаан болон мэргэжлийн байгууллагын дүгнэлт, техникийн нөхцлүүд авагдсан болно.

14. Дуудлага худалдаа явуулах газрын байршил, хил хязгаар, заагийг харуулсан зураг, схем, техникийн нөхцөл, мэргэжлийн байгууллагын дүгнэлт болон бусад дэлгэрэнгүй мэдээллийг аймгийн ГХБХБГ-ын 104 тоот өрөөнд өгч байна.

Холбоо барих утас: 70543023, 86091106, 99549278



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 1/70

Чойр

Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтууд, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүмбэр сумын 1 дүгээр багт, “НИК” ХХК-ийн албан байр, агуулахын баруун талд үйлдвэрлэлийн зориулалтаар 10,3 га газрыг газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах тухай журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдаа явуулах хугацаа, нөхцлүүдийг тодорхойлон нийтэд зарлан мэдэгдэж, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтыг газрын дарга /Д.Тамир/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 03 сарын 12 өдөр

Дугаар 4/80

Чойр


Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах
дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь хэсэг, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”, Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүмбэр сумын 1 дүгээр багийн “108 Ойл” ХХК-ийн баруун хойд талд үйлдвэрлэлийн зориулалтаар 20 га газрыг газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах тухай журмын дагуу цахим хэлбэрээр зохион байгуулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж ашиглуулахыг зөвшөөрсүгэй.

2. Дуудлага худалдаа явуулах хугацаа, нөхцлүүдийг тодорхойлон нийтэд зарлан мэдэгдэж, журмын дагуу зохион байгуулж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Отгончимэг/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.БАТСУУРЬ